



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

529.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 203	1974
530.	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төслийн талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 216	1988
531.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 222	1991
532.	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 225	1997
533.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 226	1997
534.	Жагсаалт батлах тухай	Дугаар 227	1998
535.	Тэтгэмжийн хэмжээг тогтоох, журам батлах тухай	Дугаар 228	2000
536.	Эрүүл мэндийн зарим байгууллагын нэрийг өөрчлөх тухай	Дугаар 231	2012
537.	Хөдөө аж ахуйн салбарын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 239	2013
538.	Түлш, эрчим хүчний салбарын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 240	2018



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар  
хот

### Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хатан Туул” хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны I үе шатны ажлын төлөвлөгөө (2012-2016 он)-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Усны үндэсний хорооны дарга Д.Цогтбаатар, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Туул голын сав газрын захиргаа байгуулж, захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж мөрдүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Д.ЦОГТБААТАР**

Засгийн газрын 2012 оны 203 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### “ХАТАН ТУУЛ” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага,  
өнөөгийн байдал

Туул голын сав газар нь Монгол Улсын нийт газар нутгийн гурван хувийг эзэлдэг ч 2012 оны байдлаар нийт хүн амын талаас илүү хувь буюу ойролцоогоор 1.6 сая иргэн тус сав газарт амьдарч байна. Үүнээс гадна



20 мянга гаруй үйлдвэр аж ахуйн газар, 400 га бүхий усалгаатай газар тариалан, 330 мянган толгой мал сүрэг, Монгол Улсын эрчим хүчний гол эх үүсвэр болох 3 том дулааны цахилгаан станц Туул голын экосистемд хүчтэй нөлөөлөл үзүүлж байна.

Хэрэглэгчдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд зөвхөн Улаанбаатар хотын ус хангамжид жилд шаардлагатай 77 сая шоо метр усыг зөвхөн Туул голын сав дахь газрын доорхи усны нөөцөөс хангасаар байгаа юм.

Үйлдвэрлэл, аялал жуулчлал, барилгажилт, уул уурхайн үйл ажиллагааны улмаас Туул голын эх болон эргийн ургамлан нөмрөг, ойн санд ихээхэн хохирол учирч, элэгдэл, эвдрэлд орсоор байна.

Үүнээс гадна Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагаа байнгын доголдолтой, ачааллаа даахгүй нөхцөл байдал үүссэн, хотыг тойрон байрлах гэр хорооллын нүхэн жорлон, агаар, хөрсний бохирдлоос үүдэлтэй орчны бохирдлын угаагдал зэрэг нь Туул голын бохирдлын үндсэн шалтгаан болж байна.

Улаанбаатар хот дахь 150 мянга орчим автотээврийн хэрэгслээс ялгарч байгаа утааны хийн найрлаганд этилт хар тугалга, нүүрсустөрөгч, азотын ислүүд, нүүрстөрөгчийн дутуу ислүүд зэрэг 270 гаруй төрлийн хорт бодис, мөн гэр хорооллын талхлагдаж, элэгдэлд орсон хөрс, ил задгай асгасан бохир ус, хог хаягдал, шороон зам, баригдаж байгаа болон засварт орсон барилга, элс хайрганы карьер, блок-тоосгоны үйлдвэр, айл өрхийн үнс, хөө тортог зэргээс үүсдэг тоос, тоосонцор, машин техникээс асгарсан тос нь үерийн болон борооны усаар угаагдан Туул голд шууд орж байна.

Хотын төлөвлөлтөд тусгагдаагүй газар олголт, хууль бус газар ашиглалтаас үүдэн Туул голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон тэжээгдлийн мужийн дэглэм ихээхэн зөрчигдөж байна.

Туул голын усны нөөцийн хомсдол, бохирдол жилээс жилд ихэсч экологийн доройтолд орж буй нь нийгэм, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтлана:

2.1.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлт, удирдлага нь Үндэсний хөгжлийн цогц бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр



зэрэг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн бусад хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай харилцан зохицсон байх;

2.1.2. хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлах;

2.1.3. бохирдуулагч нь төлөх, ашиглагч нь хамгаалах зарчмыг мөрдлөг болгох;

2.1.4. хөтөлбөрийн үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, нээлттэй байж, Туул голын сав газарт оршин байгаа болон нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байхын зэрэгцээ хүн амын эрэлт хэрэгцээ, оролцоо, шаардлагыг хангасан байх.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго нь Туул голын усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, бохирдлыг бууруулах чиглэлээр дунд хугацаанд боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ус хангамжийг хэвийн байлгах, нөөцийн зохистой ашиглалт бий болгох, бохирдлыг хүлцэх хэмжээнд нь хүртэл цэвэршүүлэх замаар Туул голын сав газарт оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг ханган баталгаажуулахад оршино.

3.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.2.1. Туул голын хөвөөнд орших нийслэл-Улаанбаатар хот болон бусад суурин газрууд, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг ус хангамжийн эх үүсвэрээр найдвартай хангах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс газар доорхи болон гадаргын усны судалгааг эрчимжүүлж, усны нөөц, түүний дотор ашиглалтын нөөцийг баталгаажуулах;

3.2.2. Туул голын сав газрын усны нөөцийг хамгаалан түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг хангах, усан сангууд байгуулах замаар гадаргын урсацыг нэмэгдүүлэх, урсацын тохируулга хийх боломжийг бүрдүүлэх;

3.2.3. Туул голын усны нөөц, чанарт байнгын, тасралтгүй хяналт-шинжилгээ хийх шинэ дэвшилтэт технологид суурилсан сүлжээ байгуулан мэдээлэл, удирдлагын шуурхай байдлыг хангах;



3.2.4. үйлдвэр, аж ахуйн нэгжээс Туул голын усны нөөц, чанарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг үндсэнд нь арилгах, голын усны цэвэршилтийг хангах, бохирдлыг бууруулах арга хэмжээ авах;

3.2.5. Улаанбаатар хотын бүх цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийж, бохир усны цэвэрлэгээний түвшинг стандартын шаардлагад хүргэх;

3.2.6. Туул голын сав дагуу гадаргын усны хуримтлал үүсгэх замаар үйлдвэр, цахилгаан станц, ногоон байгууламж, газар тариалангийн усны хэрэгцээг гадаргын ус болон стандартын түвшинд хүртэл цэвэрлэсэн хаягдал усаар хангах арга хэмжээ авах;

3.2.7. Туул голын хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг бүрэн зогсоож, эвдэрсэн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж дуусгах;

3.2.8. Туул голын урсац бүрэлдэх эх, түүний цутгал голуудын эхийг ойжуулах, голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг хэрэгжүүлэх замаар усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх.

#### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Хөтөлбөрийн 3.2.1-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. Улаанбаатар хотын төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжид ашиглаж байгаа Туул голын аллювийн хурдасны газрын доорхи усны нийт ордын хэмжээнд ашиглалтын хайгуул явуулж, ашиглаж болох боломжит нөөцийг дахин үнэлж баталгаажуулах, эх үүсвэрүүдийн нөхөн сэргэлтийн болон өөр хоорондын харилцан нөлөөллийг үнэлж, ашиглалтын зохистой горимыг эх үүсвэр бүрт тогтоож мөрдүүлэх;

4.1.2. сав газрын хэмжээнд Улаанбаатар хотын доод эх үүсвэр зэрэг газрын доорхи усны илрэл бүхий талбайд гидрогеологийн урьдчилсан болон нарийвчилсан хайгуул, судалгаа хийж нөөцийг баталгаажуулах;

4.1.3. "Туул усан цогцолбор" төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, гарсан үр дүнг үндэслэн цогцолборыг барих ажлыг эхлүүлэх;

4.1.4. Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сав газар дахь ус ашиглагч аж



ахуйн нэгж, байгууллагын усны хэрэглээг тооцоолж гарган, нэгдсэн зохицуулалтаар хангах.

4.2. Хөтөлбөрийн 3.2.2-т заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, Туул гол болон Тэрэлж, Сэлбэ, Дунд гол, Улиастай, Баянгол зэрэг түүний цутгал голуудын онцгой, энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх;

4.2.2. Туул голын үерийн хамгаалалтын далан болон Дунд голын голдрил дотор суурьшил бий болгож, орон сууцны барилга нэмж барихыг таслан зогсоох, хууль тогтоомж зөрчиж олгосон газрын зөвшөөрлийг хүчингүй болгох;

4.2.3. Туул голын үерийн хамгаалалтын даланг сэргээн засварлах, өргөтгөх ажлын зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх, Улаанбаатар хотын үерийн эрсдэлийн үнэлгээ хийж үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

4.3. Хөтөлбөрийн 3.2.3-т заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Улаанбаатар хотын ус хангамжийн бүх эх үүсвэрүүд, мөн томоохон ус ашиглагч (дулааны цахилгаан станцууд гэх мэт)-ийн усны чанар, хэрэглээг хянах улсын болон дотоод хяналт-шинжилгээний цооногууд байгуулж, автоматжуулах замаар усны горим, чанарын хяналт-шинжилгээг тасралтгүй явуулах техник, технологийн чадавхийг бүрдүүлэх;

4.3.2. бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч байгаа усанд хяналт тавих, хяналтын лабораториудын чадавхийг бэхжүүлэх;

4.3.3. Туул гол болон бусад цутгал голуудад ажиллаж байгаа ажиглалтын харуулын тоог нэмэгдүүлэх, ажиглалтын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх;

4.3.4. бохир усны цэвэрлэгээний түвшин, голын усны чанарын төлөв байдлын талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох;

4.3.5. Туул голын эхэд аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн байгаль орчинд нөлөөлөх



байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, нийт сав газрын хэмжээнд усны чанарын төлөв байдалд үнэлгээ өгөх.

4.4. Хөтөлбөрийн 3.2.4-т заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжуудад технологийн шинэчлэл хийсний дараа Төв цэвэрлэх байгууламжаас Төв аймгийн Алтанбулаг сум хүртэлх Туул голын голдрилын ёроолын хурдасын бохирдлыг цэвэрлэж, хоёрдогч бохирдлын эх үүсвэрийг бүрэн саармагжуулах;

4.4.2. нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар дамжуулан зохих стандартад нийцтэл цэвэрлэсний дараа төвлөрсөн ариутгах татуургын системд нийлүүлдэг тогтолцоонд шилжүүлэх;

4.4.3. гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, одоогийн хэрэглэгдэж байгаа нүхэн жорлонг шинэчлэн, гэр, орон сууцны нөхцөлд тохирсон бохирдолгүй ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх, хэсэгчилсэн байдлаар шийдэх замаар гэр хорооллоос Туул голд үзүүлж байгаа бохирдлын хэмжээг тодорхой түвшинд хүртэл бууруулах;

4.4.4. арьс, шир боловсруулах үйлдвэрийг хаягдал усаа өөрөө цэвэрлэн эргүүлж ашигладаг технологид шилжүүлсэн нөхцөлд нийслэлд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх шаардлага тавьж, эдгээр чиглэлийн үйлдвэрийн бохир усыг байгальд шууд хаях, голд нийлүүлэх явдлыг бүрэн зогсоох;

4.4.5. Дулааны цахилгаан станцуудын үнсэн сангийн усыг эргүүлэн ашиглах төсөл хэрэгжүүлэх.

4.5. Хөтөлбөрийн 3.2.5-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. Улаанбаатар хотын болон Туул голын сав газар дахь бусад цэвэрлэх байгууламжид техникийн аудит хийх, үе шаттайгаар технологийн шинэчлэл хийх;

4.5.2. Төв цэвэрлэх байгууламжид дэвшилтэт технологи нэвтрүүлж стандартын шаардлага хангуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулж, хэрэгжүүлэх;



4.5.3. Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүс, үйлдвэрлэл хөгжүүлэхээр төлөвлөсөн дүүргүүдэд байгуулах цэвэрлэх байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах;

4.5.4. төвлөрсөн шугам сүлжээнд цэвэрлэсэн бохир усыг нийлүүлдэггүй бага болон дунд оврын ус цэвэрлэх байгууламжийн ус цэвэрлэгээний чанар, түвшин, түүнд тавих хяналтыг төр болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн байгууллагуудын хамтын ажиллагааны зарчмаар шийдвэрлэх.

4.6. Хөтөлбөрийн 3.2.6-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.6.1. хаягдал усыг орчин үеийн дэвшилтэт технологиор цэвэрлэж, олон зориулалтаар дахин ашиглах зорилгоор Туул-Сонгино зэрэг төслүүдийн урьдчилсан судалгаа хийж, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах;

4.6.2. Улаанбаатар хотын орчимд шар усны үер, цас, борооны усыг хуримтлуулах усан сан, далан байгуулах боломжтой газрын нарийвчилсан судалгаа хийж, зураг төслийг гарган, зарим төслийг хэрэгжүүлж эхлэх.

4.7. Хөтөлбөрийн 3.2.7-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.7.1. Туул голын сав газар дахь хууль тогтоомжоор хориглосон, хязгаарласан газарт байрлах ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг цуцалж, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авах;

4.7.2. эрх нь цуцлагдсан болон нөөц нь дууссан элс, хайрганы ордын эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэж, аж ахуй, аялал жуулчлал, амралт сувиллын чиглэлээр тохижуулж ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

4.7.3. Туул голын дагууд эвдрэлд орсон газруудын иж бүрэн судалгаа гаргаж, нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

4.8. Хөтөлбөрийн 3.2.8-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.8.1. Туул голын эх орчимд түймэрт нэрвэгдсэн, ойн хортон шавьжид идэгдсэн болон хүний ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн ойн санг бүрэн нөхөн сэргээж, ойн хортон шавьжтай тэмцэх, түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах;





4.8.2. Сэлбэ, Улиастай, Тэрэлжийн голын эхэд ойжуулалт хийх шаардлагатай газрын судалгаа гаргаж, ойжуулан хашиж хамгаалах;

4.8.3. Туул голын урсац бүрэлдэх эх, түүний цутгал голуудын эхийн бэлчирийн даацыг тогтоож мөрдүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн

5.1. Хөтөлбөрийг 2012-2016, 2017-2020 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

5.2.1. Туул голын эхэн хэсэгт цэвэр ус хуримтлуулах боомт байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барих замаар Улаанбаатар хотын усны хэрэглээний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах арга хэмжээ авна;

5.2.2. Туул голын сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулснаар голын усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг үндсэнд нь арилгана;

5.2.3. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжуудын цэвэрлэгээний түвшин эрс дээшилсэн байна;

5.2.4. арьс, шир боловсруулах үйлдвэрүүд хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн ашигладаг технологид шилжсэн байна;

5.2.5. хүнсний чиглэлийн болон бусад боловсруулах үйлдвэрүүд урьдчилан цэвэрлэх байгууламжтай болж цэвэршүүлсэн ус нь зохих стандартын шаардлага хангасан байна;

5.2.6. Төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа усыг хуримтлуулдаг усан сан байгуулах, шар усны үер, хур борооны усыг цуглуулж гадаргын усны хуримтлал үүсгэх, голын усны урсацад тохируулга хийж усны нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх замаар газар тариалан, ногоон байгууламжийн усалгаа, үйлдвэрлэлийн хэрэглээнд газар доорхи болон цэвэр ус ашиглах явдлыг зогсоох технологийн шийдэл гаргаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ;

5.2.7. нийслэлийн гэр хорооллын ус хангамж, ариун цэврийн нөхцөлийг сайжруулснаар гэр хорооллоос Туул голд үзүүлэх бохирдлын хэмжээг тодорхой хувиар бууруулна;



5.2.8. Туул голын савд ашигт малтмалын олборлолтод өртсөн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна;

5.2.9. Туул голын урсац бүрэлдэх эх болон түүний цутгал голуудын эхийг ойжуулснаар усны нөөц нэмэгдэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх арга хэрэгсэл

6.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.1. төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Концессын гэрээний дагуу гаргах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

6.1.2. улсын болон орон нутгийн төсөв;

6.1.3. олон улсын байгууллагын хандив, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.4. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

6.1.5. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэлийн хяналт

7.1. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж зохицуулна.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүний хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын сайд нар жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.

7.3. Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн байгууллага, оролцогч талуудтай хамтран гүйцэтгэж, үр дүнг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

7.4. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр нэгтгэн гаргаж Засгийн газарт тайлагнаж байна.

Засгийн газрын 2012 оны 203 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

“ХАТАН ТУУЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
I ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (2012-2016 ОН)

№	Хөтөлбөрийн зорилт, чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа
1	Туул голын хөвөөнд орших нийслэл-Улаанбаатар хот болон бусад суурин газрууд, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг ус хангамжийн эх үүсвэрээр найдвартай хангах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс газар доорхи болон гадаргын усны судалгааг эрчимжүүлж, усны нөөц, түүний дотор ашиглалтын нөөцийг баталгаажуулах	Улаанбаатар хотын төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжид ашиглаж байгаа Туул голын аллювийн хурдасны газрын доорхи усны нийт ордын хэмжээнд ашиглалтын хайгуул явуулж, ашиглаж болох боломжит нөөцийг дахин үнэлж баталгаажуулах, эх үүсвэрүүдийн нөхөн сэргэлтийн болон өөр хоорондын харилцан нөлөөллийг үнэлж, ашиглалтын зохистой горимыг эх үүсвэр бүрт тогтоож мөрдүүлэх Сав газрын хэмжээнд Улаанбаатар хотын доод эх үүсвэр зэрэг газрын доорхи усны илрэл бүхий талбайд гидрогеологийн урьдчилсан болон нарийвчилсан хайгуул судалгаа хийж нөөцийг баталгаажуулах “Туул усан цогцолбор” төслийн техник-эдийн засгийн үнэлгээ боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, гарсан үр дүнг үндэслэн цогцолборыг барих ажлыг эхлүүлэх Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сав газар дахь ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын усны хэрэглээг тооцоолж гарган, нэгдсэн зохицуулалтаар хангах	БОАЖЯ	ЗТБХБЯ, НЗДТГ, УГ, УСУГ	2013-2014
			БОАЖЯ	ШУА, УГ	2013-2016
			БОАЖЯ	ЗТБХБЯ, НЗДТГ, УГ	2012-2016
			БОАЖЯ, ЗТБХБЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ	УГ, ТГСГЗ	2013-2016



<p>Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бус, Туул гол болон Төрлэг, Сэлбэ, Дунд гол, Улиастай, Баянгол зэрэг түүний цутгал голуудын онцгой, энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх</p>	<p>Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бус, Туул гол болон Төрлэг, Сэлбэ, Дунд гол, Улиастай, Баянгол зэрэг түүний цутгал голуудын онцгой, энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх</p>	<p>ЗТБХБЯ, БОАЖЯ, НЗДТГ</p>	<p>ГХБГЗЗГ, УГ, УСУГ</p>	<p>2012-2016</p>
<p>2</p> <p>Туул голын сав газрын усны нөөцийг хамгаалан түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг хангах, усан сангууд байгуулах замаар гадаргын урсацыг нэмэгдүүлэх, урсацын тохируулга хийх боломжийг бүрдүүлэх;</p>	<p>Туул голын үерийн хамгаалалтын далан болон Дунд голын голдрил дотор суурьшил бий болгож, орон сууцны барилга нэмж барихыг таслан зогсоох, хууль тогтоомж зөрчиж олгосон газрын зөвшөөрлийг хүчингүй болгох</p> <p>Туул голын үерийн хамгаалалтын даланг сэргээн засауулах, өргөтгөх ажлын зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх, Улаанбаатар хотын үерийн эрсдэлийн үнэлгээ хийж үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах</p>	<p>ЗТБХБЯ, ОБЕГ</p>	<p>ГХБГЗЗГ, УГ, НЗДТГ</p>	<p>2012-2015</p>
<p>3</p> <p>Туул голын усны нөөц, чанарт байнгын, тасралтгүй хяналт-шинжилгээ хийх шинэ дэвшилтэт технологийг суурилсан сүлжээ байгуулан мэдээлэл, удирдлагын шуурхай байдлыг хангах</p>	<p>Улаанбаатар хотын ус хангамжийн бүх эх үүсвэрүүд, мөн томоохон ус ашиглагч (дулааны цахилгаан станцууд гэх мэт)-ийн усны чанар, хэрэглээг хянах улсын болон дотоод хяналт-шинжилгээний цоонууд байгуулж, автоматжуулах замаар усны горим, чанарын хяналт-шинжилгээг тасралтгүй явуулах техник, технологийн чадавхийг бүрдүүлэх</p>	<p>ЗТБХБЯ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>МХЕГ, УГ, ЦУОШГ, ГХБГЗЗГ, НЗДТГ, ТТSGЗ</p>	<p>2013-2016</p>
	<p>Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч байгаа усанд хяналт тавих, хяналтын лабораториудын чадавхийг бэхжүүлэх</p>	<p>БОАЖЯ</p>	<p>УГ, ЦУОШГ</p>	<p>2013-2016</p>



	<p>Бохир усны цэвэрлэгээний түвшин, голын усны чанарын төлөв байдлын талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох</p> <p>Туул голын эхэд аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, нийт сав газрын хэмжээнд усны чанарын төлөв байдалд үнэлгээ өгөх</p>	<p>БОАЖЯ, МХЕГ, ТГСГЗ</p>	<p>аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>2012-2014</p>
<p>4</p> <p>Үйлдвэр, аж ахуйн нэгжээс Туул голын усны нөөц, чанарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг үндсэнд нь арилгах, голын усны цэвэршилтийг хангах, бохирдлыг бууруулах арга хэмжээ авах</p>	<p>Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжуудад технологийн шинэчлэл хийсний дараа Төв цэвэрлэх байгууламжаас Төв аймгийн Алтанбулаг сум хүртэлх Туул голын голдрилын ёроолын хурдасыг цэвэрлэж хоёрдогч бохирдлын эх үүсвэрийг бүрэн саармагжуулах</p> <p>Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар дамжуулан зохих стандартад нийцтэл цэвэрлэсний дараа төвлөрсөн ариулгах татуургын системд нийлүүлдэг тогтолцоонд шилжүүлэх</p> <p>Гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, одоогийн хэрэглэгдэж байгаа нүхэн жорлонг шинэчлэн, гэр, орон сууцны нөхцөлд тохирсон бохирдолгүй ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх, хэсэгчилсэн байдлаар шийдэх замаар гэр хорооллоос Туул голд үзүүлж байгаа бохирдлын хэмжээг тодорхой түвшинд хүртэл бууруулах</p>	<p>ЗТБХБЯ, БОАЖЯ</p>	<p>ТГСГЗ, аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>2014-2016</p>
		<p>БОАЖЯ, ХХААХҮЯ, МХЕГ</p>	<p>НЗДТГ, ТГСГЗ</p>	<p>2013-2014</p>
		<p>ЗТБХБЯ</p>	<p>ТГСГЗ, НЗДТГ</p>	<p>2012-2016</p>



		Арьс, шир боловсруулах үйлдвэрийг хаягдал усаа өөрөө цэвэрлэн эргүүлж ашигладаг технологид шилжүүлсэн нөхцөлд нийслэлд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх шаардлага тавьж, эдгээр чиглэлийн үйлдвэрийн бохир усыг байгальд шууд хаях, голд нийлүүлэх явдлыг бүрэн зогсоох	аймаг, нийслэлийн ЗДТГ	БОАЖЯ, ХХААХҮЯ	2012-2015
		Дулааны цахилгаан станцуудын үнсэн сангийн усыг эргүүлэн ашиглах төсөл хэрэгжүүлэх	ЭБЭХЯ	ТГСГЗ, НЭДТГ	2013-2014
		Улаанбаатар хотын болон Туул голын сав газар дахь бусад цэвэрлэх байгууламжид техникийн аудит хийх, үе шаттайгаар технологийн шинэчлэл хийх	ЗТБХБЯ, УАГ	ТГСГЗ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2013-2015
		Төв цэвэрлэх байгууламжид дэвшилтэт технологи нэвтрүүлж стандартын шаардлага хангуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулж, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	ТГСГЗ, НЭДТГ	2013-2014
5	Улаанбаатар хотын бүх цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийж, бохир усны цэвэрлэгээний түвшинг стандартын шаардлагад хүргэх	Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүс, үйлдвэрлэл хөгжүүлэхээр төлөвлөсөн дүүргүүдэд байгуулах цэвэрлэх байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл зураг төслийг боловсруулах	ЗТБХБЯ	ТГСГЗ, НЭДТГ	2013-2016
		Төвлөрсөн шугам сулжээнд цэвэрлэсэн бохир усыг нийлүүлдөггүй бага болон дунд оврын ус цэвэрлэх байгууламжийн ус цэвэрлэгээний чанар, түвшин, түүнд тавих хяналтыг төр болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн байгууллагуудын хамтын ажиллагааны зарчмаар шийдвэрлэх	ЗТБХБЯ БОАЖЯ	ТГСГЗ, НЭДТГ	2014-2016
6	Туул голын сав дагуу гадаргын усны хуримтлал үүсгэх замаар үйлдвэр, цахилгаан станц, ногоон байгууламж, газар тариалангийн усны хэрэгцээг гадаргын ус болон стандартын	Хаягдал усыг орчин үеийн дэвшилтэт технологиор цэвэрлэж, олон зориулалтаар дахин ашиглах зорилгоор Туул-Сонгино зэрэг төслүүдийн урьдчилсан судалгаа хийж, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	ЗТБХБЯ		2012-2013



<p>Түвшинд хүртэл цэвэрлэсэн хаягдал усаар хангах арга хэмжээ авах</p>	<p>Улаанбаатар хотын орчимд шар усны үер, цас, борооны усыг хуримтлуулах усан сан, далан байгуулах боломжтой газрын нарийвчилсан судалгаа хийж, зураг төслийг гарган, зарим төслийг хэрэгжүүлж эхлэх</p>	<p>БОАЖЯ, ЗТБХБЯ</p>	<p>УГ, ТГСГЗ, НЗДТГ</p>	<p>2012-2016</p>
<p>Туул голын хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг бүрэн зогсоож, эвдэрсэн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж дуусгах</p>	<p>Туул голын сав газар дахь хууль тогтоомжоор хориглосон, хязгаарласан газарт байрлах ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг цуцалж, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авах</p> <p>Эрх нь цуцлагдсан болон нөөц нь дууссан элс, хайрганы ордын эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэж, аж ахуй, аялал жуулчлал, амралт сувиллын чиглэлээр тохижуулж ашиглах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>ЭБЭХЯ, БОАЖЯ, ЗТБХБЯ</p>	<p>ТГСГЗ, аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>2013-2016</p>
<p>Туул голын урсац бүрэлдэх эх, түүний цутгал голуудын эхийг ойжуулах, голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дөглөмийг хэрэгжүүлэх замаар усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх</p>	<p>Туул голын дагууд эвдрэлд орсон газруудын иж бүрэн судалгаа гаргаж, нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх</p> <p>Туул голын эх орчимд түймэрт нэрвэгдсэн, ойн хортон шавьжид идэгдсэн болон хүний ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн ойн санг бүрэн нөхөн сэргээж, ойн хортон шавьжтай тэмцэх, түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах</p> <p>Сэлбэ, Улиастай, Тэрэлжийн голын эхэд ойжуулалт хийх шаардлагатай газрын судалгаа гаргаж, ойжуулан хашиж хамгаалах</p>	<p>БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>ЭБЭХЯ, ЗТБХБЯ, МХЕГ</p>	<p>2012-2016</p>
<p>8</p>	<p>Туул голын урсац бүрэлдэх эх, түүний цутгал голуудын эхийн бэлчирийн даацыг тогтоож мөрдүүлэх</p>	<p>БОАЖЯ, ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>ОГ, НБХГ, ТГСГЗ</p>	<p>2012-2013</p>
			<p>УГ, ОГ</p>	<p>2012-2016</p>



**Тайлбар:** БОАЖЯ-Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
ЗТБХБЯ-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам  
ХХААХҮЯ-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам  
ЭБЭХЯ-Эрдэс баялаг, эрчим хүчний яам  
ҮАГ-Үндэсний аудитын газар  
МХЕГ-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар  
НЗДТГ-Нийслэлийн засаг даргын Тамгын газар  
ТГСГЗ-Туул голын сав газрын захиргаа  
УГ-Усны газар  
ОГ-Ойн газар  
ГХБГЗЗ-Газрын харилцаа, барилга, геодези,  
зураг зүйн газар

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар  
хот

### **“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төслийн талаар авах арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.15 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төслийн мастер төлөвлөгөөний бүрдлийг хавсралтаар баталсугай.

2. Мастер төлөвлөгөө болон цогцолборын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд даалгасугай.





3. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах зардлын тооцоог гаргаж эхний ээлжинд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

4. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтэц (зам, тээвэр, эрчим хүч, усан хангамж) болон нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, дэд бүтцийг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг нарт даалгасугай.

5. Цогцолборын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг эдийн засаг, татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан 2012 оны III улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

6. Сайншанд орчмын “Бор-Хөөвөр”-ийн ордод өмнө нь судалгаагаар тогтоогдсон усны хуримтлал бүхий талбайд гидрогеологийн нарийвчилсан хайгуул хийж, ашиглах боломжит нөөцийн хэмжээг шинэчлэн тогтооход шаардагдах 1.500.0 (нэг тэрбум таван зуун) сая төгрөгийг Монгол Улсын 2013 оны төсөвт тусган санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

7. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг дагалдан хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрлэлийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг нарт даалгасугай.

8. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын санхүүжилтийн төлөвлөгөө, бүтэц, арилжааны загвар болон санхүүжилттэй холбоотой бусад асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкыг санхүүгийн зөвлөхөөр ажиллуулсугай.



9. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2012 оны 216 дугаар  
тогтоолын хавсралт

**“САЙНШАНД” АЖ ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОР ТӨСЛИЙН  
МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮРДЭЛ**

1. Хураангуй
2. Үйлдвэрүүд
3. Цогцолбор дахь дэд бүтцийн барилга, байгууламжууд
4. Бараа, материалын зохицуулалт болон тээвэрлэлтийн бүтэц, зохион байгуулалт
5. Төсөл хэрэгжих талбайн бэлтгэл
6. Байршлын харьцуулсан судалгаа
7. Олон нийтийн барилга, байгууламж
8. Тогтвортой хөгжлийн асуудлууд
9. Төсөл хэрэгжих хуваарь
10. Хөрөнгийн зардлын урьдчилсан тооцоо
11. Үйлдвэрүүдийн эдийн засгийн тооцоо
12. Санхүүжилтийн болон арилжааны бүтэц
13. Нэмэлт судалгаа

Хавсралт 13-а: Төслийн хураангуй илтгэл

Хавсралт 13-б: Бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 222

Улаанбаатар  
хот

### **Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид “ОУИТБС” гэх)-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж (цаашид “компаниуд” гэх)-үүд, салбарын мэргэжлийн холбоо (цаашид “мэргэжлийн холбоо” гэх), олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн эвсэл (цаашид “иргэний нийгмийн эвсэл” гэх)-ийн дараахь төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосугай:

1.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-6;

1.2. Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын төлөөлөл-4;

1.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-1;

1.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-8;

1.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2.

2. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, нарийн бичгийн дарга нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх байхаар тогтоосугай.

3. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн эвслийн дараахь төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

3.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-10;



3.2. Улсын Их Хурлын харьяа байгууллагын төлөөлөл-1;

3.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-2;

3.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-9;

3.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2;

3.6. Ажлын албаны зохицуулагч.

4. Ажлын хэсгийн ахлагч нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх, нарийн бичгийн дарга нь ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч байхаар тогтоосугай.

5. Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох Засгийн газрын байгууллага, Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын төлөөллийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлж байхаар тогтоосугай.

6. Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох компаниуд, мэргэжлийн холбоод, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөллийг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч, иргэний нийгмийн эвслийн төлөөллийг Иргэний нийгмийн “ТАН” эвслийн зохицуулах зөвлөлийн хурлаар, байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөллийг тус эвслийн удирдах байгууллагын хурлаар тус тус хэлэлцэн томилж, чөлөөлөн холбогдох шийдвэрээ Үндэсний зөвлөлийн даргад ирүүлснээр хүчин төгөлдөр болж байхаар тогтоосугай.

7. ОУИТБС-ын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнд хүргэж хэрэгжүүлэн, шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, түүнийг эзэмших, шилжүүлэх үйл ажиллагаа, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах талаар байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэдгээрийн хэрэгжилт, ашиглалтын өмнөх гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах ажлын явц, үр дүн, түүнд зарцуулсан зардал зэргийг тус санаачлагад нэмж хамруулахаар тогтоосугай.

8. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эзэмших, шилжүүлэх (тусгай зөвшөөрлийг компанийн



нэр, баримт бичигтэй нь хамт худалдах асуудал энд бас хамаарна), стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилт, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, экспортын хэмжээг нийтэд ил тод болгох ажлыг 2012 оноос туршилтын журмаар хэрэгжүүлж, үр дүнг Ажлын хэсэг, улмаар Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж жил бүр нийтэд ил тод мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.

9. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваад үүрэг болгосугай:

9.1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, мөн тэдгээртэй гэрээ байгуулан ажилладаг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн тухайн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, торгууль, хандив, тусламжийн аудит хийсэн тоо баримтад тулгуурлан тайланг гаргаж, нийтэд мэдээлэх ажлыг хэвшил болгон зохион байгуулж байх;

9.2. ОУИТБС-ын Засгийн газрын тайланг улсын хэмжээнд нэгтгэж байгаа Татварын ерөнхий газрын мэдээллийн сүлжээг өргөтгөн сайжруулж, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санд суурилсан вэб хандлагатай программ хангамж бий болгон төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутагт хурааж байгаа татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрч байгаа орлогын мэдээг нэгтгэн шуурхай, үнэн зөв гаргах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн тайланд нэмж тусгах;

9.3. Энэ тогтоолын 9.1-д заасан тайлангийн анхан шатны мэдээ гаргах төрийн захиргааны төв болон төрийн захиргааны холбогдох байгууллага, орон нутгийн байгууллага гаргасан мэдээгээ татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байгаа байдалд хяналт тавьж, нийтэд ил тод мэдээлэх;

9.4. Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрсөн уул уурхай, газрын тосны орлогын зарцуулалтын тайланг 2013 оноос эхлэн нийтэд мэдээлж байх бэлтгэл ажлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

10. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатарт үүрэг болгосугай:



10.1. Компаниудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах талаархи жил бүрийн тайлан, Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах ажилд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн, зарцуулсан, буцаан төлсөн байдлыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, нийтэд ил тод мэдээлж байх;

10.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргадаг ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах тайланг нийтэд ил тод мэдээлж байх арга хэмжээ авах.

11. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай:

11.1. Тухайн нутаг дэвсгэрт ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг орлогын тайланг аудит хийгдсэн санхүүгийн тоо баримтад үндэслэн гаргаж, нийтэд мэдээлэх ажлыг 2012 оноос эхлэн хэрэгжүүлэх, цаашид уг мэдээг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж, нийтэд мэдээлэх ажлыг хэвшил болгох;

11.2. Компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан орон нутгийн захиргааны байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн төлөөллийн 3 талын тэгш оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавих;

11.3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах талаар сум, дүүрэгт хүргүүлсэн аж ахуйн нэгжийн жил бүрийн тайлан, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасны дагуу сум, дүүргийн тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн байдлыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, аймаг, нийслэлийн дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийтэд ил тод мэдээлж байх;



11.4. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлж байх;

11.5. Нутаг дэвсгэрт нь уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа суманд энэ тогтоолын 11.2-т заасан дэд зөвлөлийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

12. Компани болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, мөн холбогдох гэрээний дагуу авсан төлбөр зэрэг орлогын жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байхыг холбогдох яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

13. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Үндэсний зөвлөлд даалгасугай.

13.1. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг баталж, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, удирдан зохицуулж байх;

13.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байгаа ажлын явц, үр дүнг хэлэлцэн тодорхой чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллах;

13.3. ОУИТБС-ын жилийн тайлан, мэдээллийг хэлэлцэн, тайланг аймаг, сумдад хүргэж сурталчлах зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж, үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх;

13.4. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа компаниуд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн эвслийн санал, санаачлагыг дэмжин хамтарч ажиллах;

13.5. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн, тайлангийн талаар Засгийн газар, улмаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд жил бүр тайлагнаж байх.

14. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай:



14.1. Холбогдох хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж, нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ашигт малтмалын тухай хуульд заасан арга хэмжээ авч, энэ талаар Үндэсний зөвлөлд тайлагнаж, нийтэд мэдээлж байх;

14.2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийг хянан шалгаж, нэгтгэн жил бүрийн 5 дугаар сард багтаан ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд тайлагнаж, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.

15. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн удирдлагад даалгасугай:

15.1. Улсын болон орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аудит хийсэн санхүүгийн тоо баримтад үндэслэн жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж, зохих журмын дагуу нийтэд мэдээлж байх, тайланг батлагдсан маягтын дагуу ОУИТБС-ын Ажлын албанд хүргүүлэх;

15.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулсан хөрөнгө, хийсэн ажил, түүний үр дүнг тухайн аймаг, сумын иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх, энэ чиглэлээр орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.

16. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Чиг үүрэг батлах тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 80 дугаар тогтоол, “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 225

Улаанбаатар  
хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 194 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ын 18 дахь заалтыг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“18. Цэргийн ерөнхий бэлтгэл, мэргэжлийн бэлтгэл сургалтын үе, шатыг дуусгасан гэрээт цэргийн алба хаагч нь ангийн байрлалаас гадна байрлах бөгөөд шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний жанжин штаб, Хилийн цэргийн штаб, Дотоодын цэргийн штабын шийдвэрээр тэдгээрийг ангийн байрлалд байрлуулж болно”.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД**

**Ж.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 226

Улаанбаатар  
хот

### Ой тэмдэглэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Циркийг үндэслэн байгуулагч, Монгол Улсын гавьяат жүжигчин Жамьянгийн Раднаабазар, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч, сэтгүүлч Цэндийн (Өвгөөдэй) Дамдинсүрэн нарын мэндэлсний 100 жилийн ойг 2012 онд тус тус тэмдэглэхээр тогтоосугай.

2. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.



3. Жамьянгийн Раднаабазарын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 34.3 (гучин дөрвөн сая гурван зуун мянган) сая төгрөг, Цэндийн (Өвгөөдэй) Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 26.8 (хорин зургаан сая найман зуун мянган) сая төгрөгийг 2012 оны төсвийн тодотголд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

**Ё.ОТГОНБАЯР**

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 227

Улаанбаатар  
хот

#### Жагсаалт батлах тухай

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 8.5, 8.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Агаарын бохирдлын төлбөрөөс бүрэн чөлөөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

Засгийн газрын 2012 оны 227 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

#### АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРӨӨС БҮРЭН ЧӨЛӨӨЛӨХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Нүүрсний ордын нэр
1	“Багануур” хувьцаат компани	Төв аймаг, Баяндэлгэр сум	Багануурын уурхай
2	“Шивээ-Овоо” хувьцаат компани	Говьсүмбэр аймаг, Шивээговь сум	Шивээ-Овоогийн уурхай



Засгийн газрын 2012 оны 227 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Нүүрсний уурхайн нэр
1	"Шарын гол" ХК	Дархан-Уул аймаг, Шарын гол сум	Шарын гол
2	"Адуунчулуун" ХК	Дорнод аймаг, Баянтүмэн сум	Адуунчулуун
3	"Илчит металл" ХХК	Булган аймаг, Сайхан сум	Эрээний ихэр уул
4	"Редхилл Монголия" ХХК	Сэлэнгэ аймаг, Түшиг сум	Улаан-Овоо
5	"Баянтээг" ХК	Өвөрхангай аймаг, Нарийн тээл сум	Баянтээг
6	"Могойн гол" ХК	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум	Могойн гол
7	"Хартарвагатай" ХК	Увс аймаг, Тариалан сум	Хартарвагатай
8	"Тэвшийн говь" ХХК	Дундговь аймаг, Баянцагаан сум	Тэвшийн говь
9	"Бэрх-Уул" ХК	Хэнтий аймаг, Мөрөн сум	Чандгантал
10	"Талын гал" ХК	Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум	Талбулаг
11	"Петро Коул" ХХК	Төв аймаг, Баян сум	Ховил
12	"Баялаг-Орд" ХХК	Баянхонгор аймаг, Галуут сум	Алаг цахир
13	"Гобикоул энд энержи" ХХК	Говь-Алтай, Чандмань сум	Зээгт-Шар хоолой
14	"Эрчим" ХК	Увс аймаг, Бөхмөрөн сум	Нүүрст хотгорын 1-р давхарга
15	"Хотгор" ХХК	Увс аймаг, Бөхмөрөн сум	Нүүрст хотгор
16	"Эрдэс Увс" ХХК	Увс аймаг, Тариалан сум	Их-Мянган
17	"Биг могул энд Энержи" ХХК	Дундговь аймаг, Баянжаргал сум	Хөөтийн хонхор
18	"Хотгор шанага" ХХК	Увс аймаг, Бөхмөрөн сум	Нүүрст хотгор



19	“Төгрөгнуур энержи” ХХК	Төв аймаг, Баян сум	Төгрөгнуур
20	“Мон-Ажнай” ХХК		Жилчигбулаг
21	“Чандганкоул” ХХК	Хэнтий аймаг, Мөрөн сум	Цайдам нуур

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 228

Улаанбаатар  
хот

### Тэтгэмжийн хэмжээг тогтоох, журам батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.4, 16.2, 22.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 15000 төгрөгөөр, 18 болон түүнээс дээш насны гишүүнд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 10000 төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлох, тухайн өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох болон өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хэвийн ажиллуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахад нэн тэргүүнд шаардлагатай байгаа ажилтнуудыг авч ажиллуулах, техник хэрэгсэл болон программ хангамжийг боловсронгуй болгох, гарын авлага, маягт хэвлүүлэхэд нэмж шаардагдах 2.075.9 (хоёр тэрбум далан таван сая есөн зуун мянган) төгрөгийг 2012 оны төсвийн тодотголд тусгах замаар шийдвэрлэж, төсөвт тодотгол хийх хүртэлх хугацаанд батлагдсан төсвийн багцаасаа гаргах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай.



5. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгож эхлэхтэй холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд 5, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 12, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст нутаг дэвсгэрийн хүн амын тооноос хамааруулан 4-12 хүртэл, нийт 205 ажилтныг нэмж ажиллуулах асуудлыг 2012 оны төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлэхийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

6. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох талаар олон нийтэд сурталчилж, уг ажлыг гардан зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, сум, хорооны нийгмийн ажилтнуудад зориулан сургалт зохион байгуулж, холбогдох гарын авлага бэлтгэн гаргах, тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн дэвтэр, хувийн хэрэг болон бусад маягтыг хэвлүүлэн хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай.

7. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай:

а) нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомж, журам, зааврыг иргэдэд сурталчлан таниулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

б) нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмжид хамрагдах өрхөд мэдэгдэл өгөх ажлыг зохион байгуулахад сум, хорооны нийгмийн ажилтанд дэмжлэг үзүүлэх;

в) нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмжийг хууль тогтоомжийн дагуу олгох, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авах.

8. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгох тэтгэмжийн хамрах хүрээг 2013 онд 20.000 өрхөөр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх (2012 оны инфляцийн түвшингээс багагүйгээр) арга хэмжээ авах, үүнд шаардагдах хөрөнгийг 2013 оны төсөвт тусгахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.



9. Энэхүү тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Т.ГАНДИ**

Засгийн газрын 2012 оны 228 дугаар  
тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА  
ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ӨРХИЙН ГИШҮҮН-ИРГЭНД  
ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн (цаашид “өрхийн гишүүн” гэх)-д тэтгэмж тогтоох, олгох, түүнийг зогсоохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Дараахь нөхцөлийг хангасан өрхийн гишүүн тэтгэмжид хамрагдана:

1.2.1. Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу амьжиргааны түвшингээ үнэлүүлж, мэдээлэл нь өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон;

1.2.2. өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.7-д заасан эрх бүхий этгээдийн тэтгэмж олгохоор тогтоосон босго онооноос доогуур байгаа.

1.3. Тэтгэмжийг өрхийн гишүүн тус бүрт олгох бөгөөд өрхийн насанд хүрсэн гишүүн болон хүүхдэд ялгаатай тооцож олгоно.

1.4. Өрхийн хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх боломжтой, хөдөлмөрийн чадвартай гишүүнд тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах болзолтойгоор олгоно.

1.5. Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ хийх аргачлалыг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд үндэслэн Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны



төв байгууллага хамтран батална. Энэхүү аргачлалын дагуу тэтгэмжид хамрагдаж байгаа бүх өрхийн амьжиргааны түвшинг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 3 жил тутамд үнэлж, мэдээллийг нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинэчлэн оруулна.

1.6. Тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан өрхийн амьжиргааны түвшинг энэ журмын 1.5-д заасан аргачлалын дагуу үнэлж, Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

1.7. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.2-т заасан тэтгэмжид хамруулах өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээний босго оноог нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2.1, 21.1.1, 22.1.1-д заасан үйлчилгээнд хамруулах өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээний босго оноог нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.

Хоёр. Тэтгэмжид хамрагдах өрхийг тодорхойлох,  
хүсэлтийг хянан шийдвэрлэх

2.1. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.2.2-т зааснаас доогуур байгаа өрхийн жагсаалтыг аймаг, дүүрэг, сум, хороогоор гаргаж цаасан болон цахим хэлбэрээр аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.2. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.1-д заасан жагсаалтыг тухайн шатны Засаг даргад танилцуулж, уг жагсаалтад орсон өрхөөс тухайн сум, хороонд харьяалагдах өрхийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр гаргаж сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ.

2.3. Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэхүү журмын 2.2-т заасан жагсаалтыг хүлээн аваад тухайн шатны Засаг дарга болон Амьжиргааг дэмжих зөвлөлд танилцуулж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

2.4. Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэ журмын 2.2-т заасан жагсаалтад орсон өрх бүрт тэтгэмжид хамрагдах болсон тухай мэдэгдлийг өрхийн жагсаалтыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өөрийн биеэр очиж өгнө. Мэдэгдлийг хүргэж өгөхдөө тухайн өрхийн амьжиргааны байдлыг ажиглаж, өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ бодитой эсэхэд тандалт хийнэ. Хэрэв эргэлзээтэй гэж үзвэл дахин нягтлан шалгах, өрхийн бүртгэлд оруулж холбогдох тайлбар, саналын хамт аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлж мэдэгдэл өгөхийг хойшлуулна.



2.5. Мэдэгдэл авсан өрхийг төлөөлөн өрхийн тэргүүн эсхүл 16 насанд хүрсэн аль нэг гишүүн сум, хорооны нийгмийн ажилтанд хандаж, өргөдлийн маягт бөглөн дараахь баримт бичгийг бүрдүүлж өгнө:

2.5.1. өрхийн гишүүдийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт, хэрэв 16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;

2.5.2. өрхийн гишүүдийн хаяг, ам бүлийн талаархи сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

2.5.3. өрхийн гишүүдийг төлөөлөн тэтгэмж авах иргэний 3x4 хэмжээний 2 хувь зураг.

2.6. Өргөдөлд өрхийн гишүүдийг төлөөлөн тэтгэмж авах насанд хүрсэн нэг гишүүнийг тодорхойлсон байна. Өргөдлийн маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

2.7. Сум, хорооны нийгмийн ажилтан нь хүсэлт гаргасан өрхийн өргөдлийг хүлээн авч цахим хэлбэрт оруулан, бүрдүүлсэн баримт бичгийн хамт ажлын 5 хоногт багтаан аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.8. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.7-д заасан өрхийн өргөдлийн мэдээллийг Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэлтэй тулгаж нягтлана. Хэрэв өрхийн өргөдлийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй нийцэж байвал өрхөд тэтгэмжийн дэвтэр, хувийн хэрэг нээж, сум, хорооны нийгмийн ажилтанд уг тэтгэмжийн дэвтрийг хүргүүлнэ.

Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулсан банкинд тэтгэмж авах иргэний нэрсийн жагсаалтыг хүргүүлнэ.

2.9. Энэ журмын 2.5-д заасан өргөдлийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй нийцэхгүй байвал аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тухайн өрхийг дахин нягтлан шалгах өрхийн бүртгэлд оруулж энэ тухай нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

2.10. Сум, хорооны нийгмийн ажилтан нь тухайн өрхөд тэтгэмж олгох эсэхийг өргөдөл гаргаснаас хойш 30 хоногийн дотор мэдэгдэж тэтгэмжид хамрагдах өрхөд тэтгэмжийн дэвтрийг олгож, үйлчлүүлэх банкны салбарыг зааж өгнө.





### Гурав. Тэтгэмж олгох

3.1. Тэтгэмжийг өрхийн гишүүний өргөдөл гаргасан өдрөөс эхлэн тооцож, сар бүр олгоно.

3.2. Энэ журмын 1.4-т заасан иргэн дараахь болзлыг хангасан тохиолдолд тэтгэмж авна:

3.2.1. ажил хайж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн;

3.2.2. хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржээс санал болгосон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаанд хамрагдахаас татгалзаагүй.

3.3. Энэ журмын 3.2-т заасан болзлыг иргэн хангаж байгаа эсэхэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан хяналт тавьж, сар бүрийн 20-ны дотор тухайн орон нутгийн нийгмийн ажилтанд мэдээлнэ.

3.4. Энэ журмын 3.2 дахь заалт нь дараахь иргэнд хамаарахгүй:

3.4.1. жирэмсэн болон амаржсан эх;

3.4.2. хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй бол 6 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эх (эцэг);

3.4.3. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа;

3.4.4. суралцаж байгаа.

3.5. Энэ журмын 3.4.1-3.4.3-т заасан иргэнийг харьяалах сум, хорооны нийгмийн ажилтан, 3.4.4-т заасан иргэнийг суралцаж байгаа сургалтын байгууллага нь тодорхойлно.

3.6. Тэтгэмж авч байгаа өрх нь өрхийн гишүүн нас барсан, шилжсэн, хүүхэд төрүүлсэн, үрчлэн авсан болон үрчүүлсэн зэрэг ам бүлийн тоонд орсон өөрчлөлтийг 14 хоногийн дотор сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ. Сум, хорооны нийгмийн ажилтан нь уг өөрчлөлтийн талаархи мэдээллийг авангуут аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.7. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 3.6-д заасан мэдээллийг үндэслэн Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь тухайн өрхийн мэдээллийг шинэчилж, өрхийн тэтгэмжийн хэмжээнд өөрчлөлт оруулна.



3.8. Өрхийн гишүүн нас барсан, хүүхэд төрүүлсэн, үрчлэн авсан, үрчлүүлсэн тохиолдолд тухайн гишүүнд ногдох тэтгэмжийг нэмэх буюу хасах замаар өрхийн тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоож бусад тохиолдолд тухайн өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлнэ. Өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлэх хүртэлх хугацаанд тэтгэмжийг түдгэлзүүлнэ. Дахин үнэлгээгээр өрхийн амьжиргааны түвшин нь энэ журмын 1.2.2-т заасан босго онооноос доогуур байгаа тохиолдолд өрхийн тэтгэмжийг түдгэлзүүлсэн хугацаанаас нь тооцож нөхөн олгоно.

3.9. Өрхийн гишүүдийг төлөөлөн тэтгэмж авах иргэн тэтгэмжийг банкнаас өөрийн биеэр очиж авна. Тэтгэмжийг өөрийн биеэр авч чадахгүй нөхцөлд итгэмжлэгдсэн хүнээр авахуулж болно. Итгэмжлэлийг Нотариатын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу нотариатч олгоно. Хэрэв суманд нотариатч ажиллаагүй бол сумын Засаг даргын Тамгын газрын дарга Нотариатын тухай хуулийн 10.2-т заасны дагуу итгэмжлэл олгоно.

3.10. Өрхийн гишүүдийг төлөөлөн тэтгэмж авах иргэн нас барсан, шилжсэн болон бусад шалтгаанаар авч чадахгүй болсон тохиолдолд өрхийн бусад гишүүдийн зөвшөөрснөөр 16 насанд хүрсэн өөр гишүүнд тэтгэмж авах эрхийг шилжүүлэх тухай хүсэлтийг сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

3.11. Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэ журмын 3.10-т заасан хүсэлтийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэмж авах өрхийн хувийн хэрэг болон Өрхийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулж, энэ өөрчлөлтийн талаар гэрээ байгуулсан банк болон харьяалах сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ. Сум, хорооны нийгмийн ажилтан нь мэдэгдлийг үндэслэн өрхийн тэтгэмжийн дэвтэрт өөрчлөлт оруулж баталгаажуулна.

3.12. Иргэн тэтгэмжийг өөрийн дансанд шилжүүлэх хүсэлтэй бол үйлчилгээ үзүүлж байгаа банкинд хандана.

3.13. Хүндэтгэн үзэх шалтгаанаар өрх тэтгэмжийг тухайн онд авч чадаагүй бол дараагийн жилд нөхөн олгоно. Үүнээс бусад шалтгаанаар 1 жилээс дээш хугацаагаар тэтгэмжийг аваагүй нөхцөлд түүнийг нөхөн олгохгүй.

3.14. Тэтгэмж авч байгаа өрх оршин суугаа засаг, захиргааны нэгжээсээ бүрмөсөн шилжин явж байгаа бол сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэж, тэтгэмжийн дэвтэрт тэмдэглэгээ хийлгэнэ. Сум, хорооны нийгмийн ажилтан нь тухайн өрхийн шилжилт хөдөлгөөний талаархи мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.



3.15. Тэтгэмж авч байгаа өрх аймаг, дүүрэг дотроо шилжсэн бол аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хаягийн өөрчлөлтийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулна. Тэтгэмж авч байгаа өрх аймаг, дүүрэг хооронд шилжсэн бол тухайн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд энэ тухай тэмдэглэл хийж, хувийн хэргийг хуулбарлан үлдээж эх хувийг нь тухайн өрхийн гишүүнд өгнө. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулсан өөрчлөлт бүрийг 14 хоногийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

3.16. Тэтгэмж авч байгаа өрх нь шилжин очсон засаг, захиргааны нэгжийн нийгмийн ажилтанд тэтгэмжийн дэвтэр, хувийн хэргийг хүлээлгэн өгнө. Сум, хорооны нийгмийн ажилтан нь өрхийн хувийн хэргийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд энэ тухай тэмдэглэл хийж сум, хорооны нийгмийн ажилтан болон гэрээ байгуулсан банкинд мэдэгдэнэ.

3.17. Сум, хорооны нийгмийн ажилтан нь мэдэгдлийг үндэслэн тэтгэмжийн дэвтэрт бичилт хийж, тэтгэмжийн дэвтрийг тухайн өрхийг төлөөлөн тэтгэмж авах иргэнд олгоно. Иргэн нь тэтгэмжийг шилжин очсон нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулсан банкнаас үргэлжлүүлэн авна.

3.18. Өрхийн тэтгэмжийн дэвтэр, хувийн хэрэг, бусад маягтыг иргэдэд үнэ төлбөргүй олгоно. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд тэтгэмж олгохтой холбоотой банкны үйлчилгээний хураамжийг нийгмийн халамжийн сангаас төлнө.

3.19. Тэтгэмж авч байгаа өрх тэтгэмжийн дэвтрийг хаяж үрэгдүүлсэн бол сум, хорооны нийгмийн ажилтан нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тогтоосон үнээр дэвтрийг дахин олгоно.

3.20. Шилжиж ирсэн тэтгэмжид хамрагдаж байгаа өрхөд тэтгэмжийг өмнө нь харьяалагдаж байсан засаг захиргааны нэгжид байхдаа хамгийн сүүлд тэтгэмж авсан хугацаанаас нь тасалдалгүйгээр нөхөж олгоно. Тэтгэмж авч байгаа өрх байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээс бүр мөсөн шилжсэнээс хойш 180 хоногийн дотор шилжин суурьшсан нутаг дэвсгэрийн захиргаандаа бүртгүүлээгүй бол бүртгэлгүй байсан хугацааны тэтгэмжийг нөхөн олгохгүй.

3.21. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмж авах эрх нэгэн зэрэг үүсч байгаа бол тэтгэвэр, тэтгэмжийг давхар олгоно.



3.22. Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тэтгэмж олгохдоо байнга оршин суугчийн үнэмлэхийг үндэслэнэ.

#### Дөрөв. Тэтгэмжийг зогсоох, бууруулах

##### 4.1. Тэтгэмжийг дараахь тохиолдолд зогсооно:

4.1.1. дахин үнэлгээгээр амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.2.2-т заасан босго онооноос дээш гарсан;

4.1.2. өрхийн гишүүн өөрийн хүсэлтээр тэтгэмж авахаас татгалзсан;

4.1.3. хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.1.4. тэтгэмж авах эрх үүсэхгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон.

4.2. Энэ журмын 1.4-т заасан иргэн мөн журмын 3.2-т заасан болзлыг тухайн сард хангаагүй бол аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь өрхийн дараа сарын тэтгэмжээс уг иргэнд ногдох хэсгийг хасч олгоно.

#### Тав. Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг дахин нягтлах

5.1. Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг дараахь байдлаар дахин нягтлан шалгана:

5.1.1. энэ журмын 2.4-т заасны дагуу нийгмийн ажилтан тухайн өрхийн тэтгэмжид хамрагдах мэдэгдэл өгөхийг хойшлуулсан тохиолдолд аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас томилсон өрхийн судлаач-ажилтан өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг дахин авна;

5.1.2. аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тухайн өрхийн өргөдлийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй нийцэхгүй байгаа тохиолдолд эх материал, баримт бичигтэй тулган, техникийн шинжтэй алдаа байвал залруулга хийнэ. Хэрэв өрхийн гишүүн нас барсан, хүүхэд төрүүлсэн, үрчлэн авсан, үрчлүүлсэн бол холбогдох баримт бичгийг үндэслэн Өрхийн мэдээллийн нэгдсэн санд өөрчлөлт оруулна;

5.1.3. Иргэн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээтэй санал нийлэхгүй байгаа бол сум, хорооны нийгмийн ажилтанд амьжиргааны түвшингийн үнэлгээг дахин нягтлуулах хүсэлтийг маягын дагуу гаргана. Сум, хорооны нийгмийн ажилтан нь өрхийн



хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь өрхийн судлаач-ажилтнаар ахлуулсан ажлын хэсэг томилон ажиллуулна. Багийн бүрэлдэхүүнд тухайн сум, хорооны нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн орно. Ажлын хэсэг нь өрхийн амьжиргааны түвшний судалгааны асуулгад тухайн өрх үнэн зөв хариулсан эсэхийг нягтлана. Хэрэв тухайн өрх судалгааны асуулгад үнэн зөв хариулсан бол өрхийг төлөөлөн ярилцлага хийсэн гишүүнээр мэдээллийг баталгаажуулж, энэ тухайг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад мэдэгдэж, өрхийн амьжиргааны түвшний үнэлгээг дахин нягтлах ажиллагааг дуусгана;

5.1.4. өрхийн судалгааны асуулгад өгсөн мэдээллийг зөрүүтэй гэж үзэж байгаа эсхүл өрхийн амьжиргааны түвшний судалгаа авснаас хойш мэдэгдэхүйц өөрчлөлт орсон бол ажлын хэсэг холбогдох байгууллагаас зохих мэдээллийг авч тулган нягталж, шаардлагатай гэж үзвэл өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг дахин авч, судалгааны мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

5.2. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь ажлын хэсгээс ирүүлсэн өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээллийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

5.3. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд байгаа мэдээллийг үндэслэн тухайн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээний оноог тооцон гаргаж, энэ журмын 1.2.2-т заасан босго онооноос доогуур байвал тэтгэмжид хамруулах арга хэмжээ авна.

5.4. Тэтгэмж авч байгаа өрхийн амьжиргааны түвшний талаар гуравдагч этгээд мэдээлэл өгвөл сум, хорооны нийгмийн ажилтан мэдээллийг холбогдох маягтын дагуу гаргуулж авна. Сум, хорооны нийгмийн ажилтан нь иргэний гаргасан мэдээллийн дагуу газар дээр нь очиж, мэдээлэл бодитой эсэхэд тандалт хийнэ. Хэрэв мэдээллийг бодитой гэж үзвэл тухайн өрхийг дахин нягтлах өрхийн бүртгэлд оруулан, холбогдох тайлбар, саналын хамт аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

5.5. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн ажилтны ирүүлсэн тайлбар, саналыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл тэтгэмжийг түдгэлзүүлэн энэ журмын 5.1.1, 5.2, 5.3-т заасны дагуу амьжиргааны түвшинг дахин үнэлж уг өрхөд тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох эсэхийг шийдвэрлэнэ.



## Зургаа. Амьжиргааны түвшинг үнэлүүлэх хүсэлт гаргах

6.1. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаагүй өрх амьжиргааны түвшинг үнэлүүлж, тэтгэмжид хамрагдах хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд маягтын дагуу гаргана.

6.2. Сум, хорооны нийгмийн ажилтан нь өрхийн хүсэлтийг хүлээн авч цахим хэлбэрт оруулж аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

6.3. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь өрхийн өргөдлийн мэдээллийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд байгаа мэдээлэлтэй тулгаж, өмнө нь судалгаанд хамрагдсан эсэхийг шалгана. Хэрэв тухайн өрхийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд орж үнэлгээ хийгдсэн байвал энэ тухай сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ. Сум, хорооны нийгмийн ажилтан тухайн өрхөд энэ тухай мэдэгдэнэ.

6.4. Амьжиргааны түвшинг үнэлүүлж, тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан өрхийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд ороогүй бол аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь өрхийн судлаач-ажилтанг томилон өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг тухайн өрхөөс авч, мэдээллийг Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

6.5. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд байгаа мэдээллийг үндэслэн тухайн өрхийн оноог тооцон гаргаж, энэ журмын 1.2.2-т заасан босго онооноос доогуур байвал тэтгэмж олгох арга хэмжээ авна.

6.6. Амьжиргааны түвшинг үнэлүүлж, тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан өрхийн мэдээлэл нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон боловч мэдээлэл нь зөрчилтэйн улмаас амьжиргааны түвшингийн үнэлгээний оноо бодогдоогүй бол аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага дараахь арга хэмжээг авна:

6.6.1. техникийн шинж чанартай алдааг эх материал, баримт бичиг, бусад эх үүсвэртэй тулган засварлаж, Өрхийн мэдээллийн нэгдсэн санд өөрчлөлт оруулах;

6.6.2. тухайн өрхийн мэдээллийн зөрчлийг арилгах боломжгүй бол энэ журмын 6.4-т заасны дагуу зохицуулах.

6.7. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.6-д заасны дагуу тухайн өрхийн амьжиргааны



түвшингийн үнэлгээний оноог тооцож, мөн журмын 1.2.2-т заасан босго онооноос доогуур байвал тэтгэмж олгох арга хэмжээ авна.

### Долоо. Удирдлага, зохион байгуулалт

7.1. Тэтгэмж олгох ажлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

7.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тэтгэмж олгох ажлыг зохион байгуулах, Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сүлжээ, тогтолцоог хэвийн ажиллуулах, шинэчлэх үүрэг хүлээх бөгөөд энэ асуудлыг хариуцсан албатай байна. Алба нь өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээний болон Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.2-т заасан тэтгэмж, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2.1, 21.1.1, 22.1.1-д заасан үйлчилгээнд хамруулах босго оноог тооцох арга зүйч мэргэжилтэн, өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа, үнэлгээний арга зүйч, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн, мэдээллийн технологийн ахлах инженер, Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн администратор, программын системийн инженер, техникийн ажилтан зэрэг мэргэжилтэнтэй байна.

7.3. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сүлжээ, тогтолцоог хэвийн ажиллуулах, шинэчлэх үүрэг бүхий нэгж байна. Уг нэгжид тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тооноос хамааруулан орон тооны нийгмийн ахлах ажилтан, өрхийн судлаач-ажилтан, мэдээллийн технологийн ажилтан, оператор зэрэг ажиллана.

### Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

8.1. Тэтгэмжийн олголт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргийг мэргэжлийн хяналтын болон аудитын байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж тус тусынхаа эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

8.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.2, 20.2.1, 21.1.1, 22.1.1-д заасан тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан өрхийн аж байдалтай түүвэрлэн танилцах, санал, хүсэлтийг нь судлах зэргээр тэтгэмж, үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг үнэлэх ажлыг эрүүл мэндийн болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд



тэтгэмж, үйлчилгээний үр нөлөөг үнэлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

#### Ес. Бусад

9.1. Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг дахин нягталсан боловч Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.2, 20.2.1, 21.1.1, 22.1.1-д заасан тэтгэмж, үйлчилгээнд хамрагдах эрх үүсээгүй бол тухайн өрхийн амьжиргааны түвшинг сүүлийн үнэлгээ хийгдсэнээс хойш 1 жилийн хугацаанд дахин үнэлэхгүй.

9.2. Тэтгэмж авч байгаа өрх нь энэ журмын 3.6-д заасан өөрчлөлтийг тогтоосон хугацаанд мэдэгдээгүй бол илүү авсан хугацааных нь тэтгэмжийг эхний удаа нөхөн төлүүлэх буюу дараа сарынх нь тэтгэмжээс суутгана.

9.3. Энэ журмын 9.2-т заасан зөрчлийг давтан гаргасан тохиолдолд тэтгэмжийг нөхөн төлүүлэх буюу дараа сарын тэтгэмжээс суутгаж, Нийгмийн халамжийн тухай хуулийн 31.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.4. Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 231

Улаанбаатар  
хот

#### Эрүүл мэндийн зарим байгууллагын нэрийг өөрчлөх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдөр баталсан Эрүүл мэндийн тухай хуулиар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан эрүүл мэндийн зарим байгууллагын нэрийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

1.1. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл (хуучин нэрээр)-ийн тогтоолоор байгуулагдсан Эх нялхсын эрдэм шинжилгээний үндэсний төвийг “Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв”, Арьсны өвчин судлалын төвийг “Арьсны өвчин судлалын үндэсний төв”, Байгалийн





голомтот халдварт өвчин судлалын үндэсний төвийг “Зоонозын өвчин судлалын үндэсний төв”, Улсын клиникийн төв эмнэлгийг “Улсын нэгдүгээр төв эмнэлэг”, Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийг “Улсын хоёрдугаар төв эмнэлэг”, П.Н.Шастины нэрэмжит төв эмнэлгийг “Улсын гуравдугаар төв эмнэлэг”, Нялхсын клиникийн сувиллыг “Хүүхдийн төв сувилал” гэж;

1.2. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор байгуулагдсан Эмгэг судлалын төвийг “Эмгэг судлалын үндэсний төв”, “Геронтологийн төв байгуулах тухай” Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолоор байгуулагдсан Геронтологийн төвийг “Геронтологийн үндэсний төв” гэж.

2. “Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Шинжлэх ухааны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт хийх чиглэл”-ийн 20 дахь заалтад “Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв” гэж өөрчилсүгэй.

3. Эрүүл мэндийн сайдын шийдвэрээр байгуулагдсан эрүүл мэндийн байгууллагын нэрийг Эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөн үүнтэй холбогдон гарах зардлыг төсвийн багцаасаа санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

**Н.ХҮРЭЛБААТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 7 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар  
хот

**Хөдөө аж ахуйн салбарын 2012-2013 оны  
өвөлжилтийн бэлтгэл хангах зарим  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх доод хэмжээг 1 дүгээр хавсралт, аймаг, нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах



зорилгоор орон нутгийн мах боловсруулах үйлдвэрүүдэд бэлтгэх нөөцийн махны хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Мал аж ахуйн салбарын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл хангах талаар тодорхой төлөвлөгөө гарган зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэж ажиллах;

2.2. Малчид, иргэд, аж ахуйн нэгжийн хадлан, тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаж аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх явцад хяналт тавих;

2.3. Мал сүргийн зун, намрын отрыг сайтар зохион байгуулж, тарга хүч авахуулах;

2.4. Аймаг, сум дундын отрын бүс нутагт уст цэг гаргах, засварлах, нэг болон олон наст тэжээлийн ургамал тариалах замаар бэлчээрийг нөхөн сэргээж сайжруулж, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, шаардлагатай бол холбогдох орон нутгийн удирдлагатай отор нүүдлийн гэрээ байгуулж хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5. Төрийн болон орон нутгийн өмчит цөм сүргийн аж ахуйгаас үржлийн хээлтүүлэгч мал бойжуулах ажлыг зохион байгуулж хээлтүүлэгч дутагдалтай аймаг, бүс нутгийг хангах, мэргэжлийн байгууллагатай хамтран үржлийн биотехнологийн аргуудыг өргөн ашиглах, малыг бүртгэлжүүлэх, эзэмэжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

2.6. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах тарилга, эм бэлдмэлийг орон нутагт хүргүүлж малын угаалга, тарилга, туулгалт, вакцинжуулалт болон ариутгал, халдваргүйжүүлэлт, тандалт шинжилгээ, оношилгоог технологийн хугацаанд нь шуурхай зохион байгуулах;

2.7. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр худаг гаргах болон бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлын явцад хийх гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах;

2.8. Хөрш орнуудаас хил дамжсан хортон шавьжийн нүүдэл орж ирэх магадлал өндөр байгааг харгалзан малчид, тариаланчдыг



сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд хортон шавьжийн устгал зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын чиглэл, төлөвлөгөө гаргаж ажиллах;

2.9. Орон нутгийн мах боловсруулах үйлдвэрүүдэд нөөцийн мал, мах бэлтгэх ажилд хяналт тавьж, хот, суурин газрын 2013 оны хавар хэрэглэх махны нөөцийг хангалттай бүрдүүлэх, үнийг тогтвортой байлгах ажлыг зохион байгуулах;

2.10. Ургац хураалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, ургац хураах, хадлан тэжээл бэлтгэх ажилд шаардагдах шатахууны хангамжийг хэвийн байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.11. Үр тариа, төмс, хүнсний ногоо хадгалах элеватор, агуулах, зоорийн бэлэн байдлыг шалгаж, ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж, хадгалах нөхцөлийг сайжруулах.

3. Улсын нөөцийн өвс, тэжээлийг тогтоосон хэмжээ, байршлын дагуу хүйтний улирлын өмнө бүрдүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаярт үүрэг болгосугай.

4. Зуны агаарын хэт халалт, хуурайшилт, ган, үер зэрэг байгалийн үзэгдлийн үед хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, цаг агаарын мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах, гамшигт үзэгдэл тохиолдсон үед шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг сар бүр хянан шалгаж, малчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тавьсан санал, хүсэлтийг судлан шуурхай шийдвэрлэж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Малчин өрх бүр малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг өрх болон малчид хоршин нөөцлөх, малчин бүр өвлийн хувцас хэрэглэл, мал аж ахуйн тоног хэрэгслийг засварлах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангахыг малчин өрх, мал бүхий иргэдэд уриалсугай.



7. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, мал өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг нэгтгэн 2012 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2012 оны 239 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН  
АЮУЛГҮЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ДООД ХЭМЖЭЭ**

№	Аймгийн нэр	Аймаг, нийслэлийн аюулгүйн нөөц		Сум, дүүрэг бүрийн аюулгүйн нөөц	
		Өвс (тн)	Тэжээл (тн)	Өвс (тн)	Тэжээл (тн)
1	Архангай	1000	200	100	50
2	Баян-Өлгий	800	200	100	50
3	Баянхонгор	400	200	50	50
4	Булган	1200	300	100	50
5	Говь-Алтай	400	200	50	50
6	Говьсүмбэр	200	100	50	50
7	Дархан-Уул	800	200	100	50
8	Дундговь	500	200	50	50
9	Дорноговь	300	100	50	50
10	Дорнод	1000	200	100	50
11	Завхан	1200	200	100	50
12	Орхон	500	150	100	70
13	Өвөрхангай	1200	300	100	70
14	Өмнөговь	300	100	50	50
15	Сэлэнгэ	1200	400	100	80
16	Сүхбаатар	800	200	100	50
17	Төв	1200	300	100	50
18	Увс	1000	400	80	40
19	Ховд	1000	300	80	40
20	Хөвсгөл	1200	300	100	50
21	Хэнтий	1000	300	100	50
22	Улаанбаатар	400	200	50	50
	Дүн	17600	5050		



Засгийн газрын 2012 оны 239 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ  
САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ОРОН НУТГИЙН МАХ  
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮДЭД БЭЛТГЭХ  
НӨӨЦИЙН МАХНЫ ХЭМЖЭЭ

Аймаг	2012 оны эхний нийт мал, мян.тол	Бэлтгэн нийлүүлэх нийт махны хэмжээ, мян.тн					Үүнээс: нөөцөд бэлтгэх махны хэмжээ, мян. тн
		үхрийн мах	адууны мах	ямааны мах	хонины мах	нийт бэлтгэх мах	
Баруун бүс:							
Баян-Өлгий	1302.8	0.0	0.6	2.8	3.2	6.6	0.5
Говь-Алтай	1613.3	0.5	0.8	3.8	2	7.1	0.5
Завхан	2006.1	1.8	1.6	3.8	6	13.2	0.9
Увс	1831.8	1.4	1.0	3.3	4.4	10.1	0.7
Ховд	1771.3	1.4	1.0	4.3	3.6	10.3	0.7
Дүн	8525.3	5.1	5.1	18.1	19.2	47.3	3.3
Хангайн бүс:							
Архангай	2984.3	8.6	3.1	4.5	9.2	25.4	1.8
Баянхонгор	2237.8	2.8	1.4	5.9	3.7	13.8	1.0
Булган	2340.8	3.7	1.9	3.2	6.6	15.4	1.1
Орхон	168.3	1.1	0.1	0.2	0.4	1.8	0.1
Өвөрхангай	2425.6	2.8	2.3	4.8	6.3	16.2	1.1
Хөвсгөл	3315.5	7.4	2.7	6.2	7.2	23.5	1.6
Дүн	13472.3	25.4	11.5	24.8	33.5	96.2	6.7
Төвийн бүс:							
Говьсүмбэр	189.7	0.0	0.1	0.4	0.4	0.9	0.1
Дархан-Уул	256.8	0.0	0.1	0.3	0.5	0.9	0.1
Дорноговь	1207.4	0.6	1.1	2.9	3.2	7.8	0.5
Дундговь	1348.7	0.3	0.8	2.5	3.5	7.1	0.5
Өмнөговь	1223.5	0.2	0.7	3.2	1.2	5.3	0.4
Сэлэнгэ	1260.9	2.3	0.8	1.9	2.9	7.9	0.5
Төв	2962	3.1	2.9	4.8	8.3	19.1	1.3
Дүн	8448.8	6.5	5.7	13.5	16.5	49.0	3.4
Зүүн бүс:							
Дорнод	1149.8	1.8	1.6	1.3	2.6	7.3	0.5
Сүхбаатар	2081.4	2.2	1.9	3.9	6.2	14.2	1.0
Хэнтий	2379.1	2.5	1.8	3.2	5.1	12.6	0.9
Дүн	5610.3	6.5	5.3	8.4	13.9	34.10	2.4
Улаанбаатар:							
Улаанбаатар	278.9	0.0	0.3	0.2	0.3	0.8	0.1
Бүгд	36335.8	40.1	27.9	65.1	83.3	226.5	15.9



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 240

Улаанбаатар  
хот

### **Түлш, эрчим хүчний салбарын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай**

Эрчим хүчний тухай хуулийн 5.1.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түлш, эрчим хүчний үйлдвэр, компаниудын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үндсэн болон туслах тоноглолын засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулж, хяналт тавьж ажиллан үр дүнг Засгийн газарт сар тутам танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан эрчим хүчний зарим үйлдвэр, компанид 2013 онд шаардлагатай байгаа татаасын тооцоог хянаж, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

3. Төрийн өмчит дулааны цахилгаан станцын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 20-иос доошгүй хоногийн нүүрсний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, нүүрс тээвэрлэх вагоноор тасралтгүй, найдвартай хангах арга хэмжээ авч, нүүрс тээвэрлэлтийн график төлөвлөгөө гарган ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж нарт даалгасугай.

4. Нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангахад хүрэлцэхүйц хэмжээний дизель түлш, шатахууны нөөц бүрдүүлэн хөрс хуулалт, их засвар, ашиглалтын үйл ажиллагааг жигд зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал), холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Дараахь арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй:

5.1. “Багануур” ХК-ийн найдвартай ажиллагаа, 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангахад зориулж техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээнд болон дизель түлшний нөөц бүрдүүлэхэд шаардагдах



хөрөнгийн эх үүсвэрт зориулан 3.2 (гурван тэрбум хоёр зуун сая) тэрбум төгрөгийн төсвийн зээл олгох;

5.2. Завхан аймгийн Улиастай сумын дизелийн цахилгаан станцын дизелийн түлшний зардалд шаардлагатай байгаа 574.5 (таван зуун далан дөрвөн сая таван зуун мянган) сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргах.

6. “Багануур” ХК-д төсвөөс олгосон зээлийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, 2012 онд багтаан энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хуваарийн дагуу эргэн төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгасугай.

7. Аймгийн төвийн эрчим хүчний үйлдвэр, дулааны станц, дизель станцын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд онцгой анхаарч төлөвлөсөн их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулж, хяналт тавьж ажиллах, түүнчлэн нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах ажлыг зохих төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгуулан ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

Засгийн газрын 2012 оны 240 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭР, КОМПАНИД ШААРДЛАГАТАЙ  
ТАТААСЫН ХЭМЖЭЭ**

(мян.төгрөгөөр)

Үйлдвэр, компанийн нэр		2012 онд батлагдсан төсөв	2013 онд шаардагдах
Нийт татаасын хэмжээ		25.605.900.0	24.466.500.0
А. Дизелийн станцын алдагдлын татаас		8.852.000.0	8.545.000.0
1	Говь-Алтай аймгийн Эрчим хүчний үйлдвэр	4.132.000.0	3.500.000.0
2	Завхан аймгийн Эрчим хүчний үйлдвэр	3.000.000.0	4.000.000.0
3	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Эрчим хүчний үйлдвэр	500.000.0	500.000.0
4	Говь-Алтай аймгийн эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй сумдын дизель түлшний үнэ	447.000.0	232.500.0



5	Завхан аймгийн эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй сумдын дизель түлшний үнэ	653.000.0	232.500.0
6	Баянхонгор аймгийн эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй сумдын дизель түлшний үнэ	120.000.0	80.000.0
Б. Цахилгаан дамжуулах системийн алдагдлын татаас		10.548.000.0	9.670.600.0
1	“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ХК	2.200.000.0	2.200.000.0
2	“Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК	6.470.600.0	6.470.600.0
3	“Алтай-Улиастай эрчим хүчний систем” ХК	1.877.400.0	1.000.000.0
В. Дулааны станцын алдагдлын татаас		6.205.900.0	6.250.900.0
1	“Даланзадгадын Дулааны цахилгаан станц” ХК	1.800.000.0	1.800.000.0
2	“Налайхын дулааны станц” ХК	1.645.800.0	1.645.800.0
3	“Багануурын дулааны станц” ХК	1.455.100.0	1.455.100.0
4	“Дулаан-Шарын гол” ХК	500.000.0	500.000.0
5	Хэнтий аймгийн “Хэнтий-Ус” ХХК-ийн Бэрх тосгоны дулааны станц	305.000.0	350.000.0
6	Хөтөл тосгоны дулааны станц	500.000.0	500.000.0

Засгийн газрын 2012 оны 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

“БАГАНУУР” ХК-ИЙН ТӨСВИЙН ЗЭЭЛИЙН  
ЭРГЭН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХУВААРЬ

(сая төгрөг)

№	Эргэн төлөх хугацаа	Эргэн төлөх хэмжээ
1	2012 оны 9 сар	800.0
2	2012 оны 10 сар	800.0
3	2012 оны 11 сар	800.0
4	2012 оны 12 сар	800.0
Нийт дүн		3200.0

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiiin\_medecelel@parliament.mn  
Утас: 262420, 329612  
Хэвлэлийн хуудас: 3  
Индекс: 14003